УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/118/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: А.Нанжидмаа
Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .......... 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .......... 3
3. Аудитын тайлан .......... 12
   3.1 Ерөнхий зүйл .......... 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .......... 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .......... 12
   3.4 Материаллаг байдал .......... 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .......... 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .......... 13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......... 14
   3.8 Аудитын гол асуудал .......... 15
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 15



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/118/НА-СТАЭШ/3
танай ______ -ны № ______ -т

УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 6 ДУГААР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.ОРШИХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200245

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **116,112,410.08** | **136,337,419.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **116,112,410.08** | **136,337,419.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,1789,00.20 | 18,178,900.20 |
| 35130 | Эм боох материал | 77,600.00 | |
| **35400** | **Хангамжийн материал** | **97,855,909.88** | **118,158,518.80** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 236,450.00 | 12,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 265,960.00 | 120,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 97,353,499.88 | 118,026,518.80 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,934,930,673.47** | **3,062,152,675.42** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,934,930,673.47** | **3,062152,675.42** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,580,949,784.59** | **2,708,938,453.22** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,533,967,238.67 | 2,633,519,685.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (129,394,588.42) | (197,327,523.46) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 313,305,922.07 | 433,858,342.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (224,700,014.78) | (255,673,031.00) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 128,852,066.70 | 130,038,226.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (95,159,959.85) | (92,903,842.10) |
| 39217 | Ном | 54,079,120.20 | 57,426,595.64 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **353,980,888.88** | **353,214,222.20** |
| 39301 | Программ хангамж | 2,850,000.00 | 2,850,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,461,111.12) | (2,227,777.80) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 352,592,000.00 | 352,592,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,051,043,083.55** | **3,198,490,094.42** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0 | 0 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0** | **0** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,051,043,083.55** | **3,198,490,094.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **3,051,043,083.55** | **3,198,490,094.42** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,207,633,684.03 | 2,207,633,684.03 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(42,658,931.79)** | **104,788,079.08** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (42,658,931.79) | (42.658,931.79) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 147,447,010.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 886,068,331.31 | 886,068,331.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,051,043,083.55** | **3,198,490,094.42** |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,736,245,043.68** | **1,822,910,186.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,733,804,043.68** | **1,809,881,855.76** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **79,340,843.68** | **229,622,608.76** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **68,923,103.60** | **223,385,886.44** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,668,000.00 | 19,888,444.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 50,255,103.60 | 203,497,442.44 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал | 10,417,740.08 | 6,236,722.32 |
| **122005** | **Төсвөөс санхүүжих** | **188,811,000.00** | **202,508,447.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,465,652,200.00** | **1,377,750,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | **1,465,652,200.00** | **1,377,750,800.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,441,000.00** | **13,028,331.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,441,000.00 | 10,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 928,331.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,730,139,595.51** | **1,673,996,731.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,730,139,595.51** | **1,673,996,731.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,612,551,570.51** | **1,609,973,694.33** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,133,551,605.00** | **1,113,658,080.00** |
| 210101 | Үндсэн цалин | 782,460,512.00 | 788,521,652.00 |
| 210102 | Нэмэгдэл | 246,060,873.00 | 250,633,570.00 |
| 210104 | Урамшуулал | 105,030,220.00 | 74,502,858.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **142,948,374.00** | **145,671,794.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,907,930.00 | 103,421,794.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,338,990.00 | 10,976,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,026,656.00 | 8,781,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,198,282.00 | 2,261,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,476,516.00 | 20,231,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **180,755,212.00** | **194,508,947.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,610,415.00 | 4,754,313.00 |
| 210302 | Түлш, халаалт | 165,957,684.00 | 177,275,648.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,187,113.00 | 12,478,986.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **15,479,900.00** | **20,870,967.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,617,010.00 | 1,482,260.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,533,500.00 | 2,830,000.00 |



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 806,600.00 | 3,046,194.00 |
| 210405 | Хог хаягдал устгах,цэвэрлэх | 2,950,000.00 | 2,609,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,572,790.00 | 6,145,110.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 4,758,403.40 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,707,600.00** | **967,950.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 386,600.00 | 547,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,205,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 116,000.00 | 420,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,000,000.00** | **8,749,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 8,749,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **2,151,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,151,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,716,000.00** | **1,939,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 840,000.00 | 550,000.00 |
| 210802 | Аудит,баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 576,000.00 | 806,400.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 300,000.00 | 583,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **127,392,879.51** | **121,456,055.93** |
| 210902 | Хичээл сургалтын,үйлдвэрлэлийн дадлагын зардал | 7,257,760.00 | 13,542,160.00 |
| 210903 | үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 120,135,119.51 | 107,913,895.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,588,025.00** | **64,023,037.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **32,660,800.00** | **53,894,750.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,668,800.00 | 41,867,750.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,992,000.00 | 12,027,000.00 |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | 84,871,437.00 | 10,128,287.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **6,105,448.17** | **148,913,455.43** |
| | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 1,466,444.56 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН(VI=IV-V)** | | **(1,466,444.56)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **6,105,448.17** | **147,447,010.87** |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **2,207,633,684.03** | **886,068,331.31** | **-42,658,931.79** | **3,051,043,083.55** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | | | | |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | | | | |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | | | | |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | | | | |
| 7 | **Өмчид гарсан өөрчлөлт** | | | | |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | | | | |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | | | | |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,207,633,684.03** | **886,068,331.31** | **-42,658,931.79** | **3,051,043,083.55** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,207,633,684.03** | **886,068,331.31** | **-42,658,931.79** | **3,051,043,083.55** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,207,633,684.03** | **886,068,331.31** | **-42,658,931.79** | **3,051,043,083.55** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ногдол ашиг | | | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | 147,447,010.87 | 147,447,010.87 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **2,207,633,684.03** | **886,068,331.31** | **104,788,079.08** | **3,198,490,094.42** |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,675,572,200.00** | **1,613,176,022.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,673,131,200.00** | **1,600,147,691.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **18,668,000.00** | **19,888,444.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **18,668,000.00** | **19,888,444.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 18,668,000.00 | 19,888,444.00 |
| **122005** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **188,811,000.00** | **202,508,447.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,465,652,200.00** | **1,377,750,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,465,652,200.00 | 1,377,750,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,441,000.00** | **13,028,331.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,441,000.00 | 10,600,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 928,331.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,675,572,200.00** | **1,613,176,022.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,675,572,200.00** | **1,613,176,022.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,557,984,175.00** | **1,549,152,985.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,133,756,940.00** | **1,113,658,080.00** |
| 210101 | Үндсэн цалин | 784,854,508.00 | 788,521,652.00 |
| 210102 | Нэмэгдэл | 243,872,212.00 | 250,633,570.00 |
| 210104 | Урамшуулал | 105,030,220.00 | 74,502,858.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **142,727,353.00** | **145,671,794.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,686,909.00 | 103,421,794.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,338,990.00 | 10,976,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,026,656.00 | 8,781,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,198,282.00 | 2,261,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,476,516.00 | 20,231,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **180,755,212.00** | **194,508,947.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,610,415.00 | 4,754,313.00 |
| 210302 | Түлш, халаалт | 165,957,684.00 | 177,275,648.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,187,113.00 | 12,478,986.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,573,210.00** | **22,675,004.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,853,460.00 | 1,482,260.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,533,500.00 | 2,830,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 806,600.00 | 3,046,194.00 |
| 210404 | Ном хэвлэл | 770,000.00 | 776,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал | 2,950,000,00 | 2,609,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 22,659,650.00 | 11,931,550.00 |
| **2105** | **Норматив зардал** | **3,837,700.00** | **1,638,350.00** |



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 464,200.00 | 470,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,205,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,168,500.00 | 1,168,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **57,360,000.00** | **40,328,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 44,360,000.00 | 19,828,900.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 12,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 7,999,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **2,151,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,151,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,716,000.00** | **1,939,400.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 840,000.00 | 550,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 576,000.00 | 806,400.00 |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 300,000.00 | 583,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,257,760.00** | **26,582,010.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,257,760.00 | 26,582,010.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **117,588,025.00** | **64,023,037.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **32,660,800.00** | **53,894,750.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 26,668,800.00 | 41,867,750.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,992,000.00 | 12,027,000.00 |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | 84,871,437.00 | 10,128,287.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | 0 | 0 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 0 | 0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 0 | 0 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 0 | 0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 0 | 0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | 0 | 0 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | 0 | 0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 0 | 0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,601,519,000.00 | 1,590,019,735.00 | 11,499,265.00 | 99.3 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,601,519,000.00 | 1,590,019,735.00 | 11,499,265.00 | 99.3 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,544,697,900.00 | 1,539,109,985.00 | 5,587,915.00 | 99.6 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,113,766,200.00 | 1,113,658,080.00 | 108,120.00 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 788,521,800.00 | 788,521,652.00 | 148.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 250,666,000.00 | 250,633,570.00 | 32,430.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 74,578,400.00 | 74,502,858.00 | 75,542.00 | 99,9% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 150,358,500.00 | 145,671,794.00 | 4,686,706.00 | 96.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,807,800.00 | 103,421,794.00 | 2,386,006.00 | 97.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,137,700.00 | 10,976,100.00 | 161,600.00 | 98.5 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,910,100.00 | 8,781,200.00 | 128,900.00 | 98.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,227,600.00 | 2,261,300.00 | -33,700.00 | 101.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,275,300.00 | 20,231,400.00 | 2,043,900.00 | 90.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 195,256,200.00 | 194,508,947.00 | 747,253.00 | 99.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 4,754,313.00 | 745,687.00 | 86.4 |
| 210302 | Түлш, халаалт | 177,275,600.00 | 177,275,648.00 | -48.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,480,600.00 | 12,478,986.00 | 1,614.00 | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,227,500.00 | 21,200,904.00 | 26,596.00 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 863,500.00 | 863,260.00 | 240.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,734,200.00 | 2,730,000.00 | 4,200.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэт | 3,060,300.00 | 3,046,194.00 | 14,106.00 | 99.5 |
| 210404 | Ном хэвлэл | 781,500.00 | 776,000.00 | 5,500.00 | 99.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах | 2,300,000.00 | 2,300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,488,000.00 | 11,485,450.00 | 2,550.00 | 100.0 |
| **2105** | **Норматив зардал** | 1,640,600.00 | 1,638,350.00 | 2,250.00 | 99.9 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 471,100.00 | 470,350.00 | 750.00 | 99.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,169,500.00 | 1,168,000.00 | 1,500.00 | 99,9% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **35,000,000.00** | **34,999,500.00** | **500.00** | 100,0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,500,000.00 | 14,500,000.00 | | 100,0% |
| 210602 | Тавилга эд хогшил | 12,500,000.00 | 12,500,000.00 | | 100,0% |
| 210604 | Урсгал засвар | 8,000,000.00 | 7,999,500.00 | 500.00 | 100,0% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,160,800.00** | **2,151,000.00** | **9,800.00** | 99,5% |
| 210702 | Дотоод албан томилолт | **2,160,800.00** | **2,151,000.00** | **9,800.00** | 99,5% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,606,400.00** | **1,604,400.00** | **2,000.00** | 99,9% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 500,000.00 | | 100,0% |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | 806,400.00 | | |
| 210806 | Мэдээлэл,технологийн үйлчилгээ | 300,000.00 | 298,000.00 | 2000.00 | 99,3% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **23,681,700.00** | **23,677,010.00** | **4,690.00** | 100,0% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 23,681,700.00 | 23,677,010.00 | 4,690.00 | 100,0% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,821,100.00** | **50909750.00** | **5,911,350.00** | **89.6** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **56,821,100.00** | **50909750.00** | **5,911,350.00** | **89.6** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 47,779,100.00 | 41,867,750.00 | 5,911,350.00 | 87,6% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,042,000.00 | 9,042,000.00 | | 100,0% |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | | |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | | | |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,581,007,000.0** | **1,590,019,735.00** | **11,499,265.00** | **99.3** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,581,007,000.00 | 1,570,131,291.00 | 10,875,709.00 | 99.3 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | | | |
| 350002 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 20,512,000.00 | 19,888,444.00 | 623,556.00 | 97,0% |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 13,028,000.00 | | 100,0% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 13,028,000.00 | | 100,0% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 10,043,000.00 | 331.00 | 100,0% |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | | 1,474,100.00 | 331.00 | 100,0% |
| 210401 | Бичиг хэрэг | | 619,000.00 | 131.00 | 100,0% |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 100,000.00 | | 100,0% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах | | 309,000.00 | 200.0 | 99,9% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 446,100.00 | | 100,0% |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | | 5,328,900.00 | | 100,0% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 5,328,900.00 | | 100,0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **335,000.00** | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 50,000.00 | | |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | | 2,905,000.00 | | 100,0% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,905,000.00 | | 100,0% |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 2,985,000.00 | (331.00) | |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | | | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 2,985,000.00 | | |
| | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | 331.00 | |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 13,028,331.00 | | 100,0% |
| **31** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **13,028,000.00** | | 100,0% |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,500,000.00 | | 100,0% |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,600,000.00 | | 100,0% |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 928,000.00 | | 100,0% |



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургууль нь "Бүх нийтийн ерөнхий боловсролыг суралцагчдад эзэмшүүлэх" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 8,650.7 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,673,996.7 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 8,369.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 6,695.9 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 147,447.0 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 116,112.4 | 136,337.4 | 20,225.0 |
| Үндсэн хөрөнгө | 2,934,930.6 | 3,062,152.6 | 11,109.5 |
| **Нийт хөрөнгө** | 3,051,043.0 | 3,198,490.0 | 147,447.0 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,051,043.0 | 3,198,490.0 | 147,447.0 |

Бараа материалын дансны үлдэгдэл 136,337.4 мянган төгрөг болж 20,225.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 49,644.6 мянга, хандив,хөрөнгө оруулалтаар 6,236,7.3 мянга, нийт 55,881.3 бараа материал орлогод авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,062,152.6 мянган төгрөг болж 11,109.5 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй 202,847.4 мянга, төсвийн хөрөнгөөр 33,754.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,207,633.6 Хуримтлагдсан үр дүн 104,788.0 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 86,665.1 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт зардал өмнөх оноос 56,142.8 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин хөлс нэмэгдэл урамшуулал,бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь норматив зардал,элэгдлийн зардал,төвлөрүүлэх шилжүүлэг буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаангом сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,195,504.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,715,458.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 274,793.6 мянган төгрөгөөр бууруулж 1,440,665.0 мянган төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 1,601,519.0 мянган төгрөг баталсан байна. Энэ нь урьд оны гүйцэтгэлээр төсөв баталдагтай холбоотой байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,601,519.0 мянган төгрөгийн төсөв батласнаас улсын төсвөөс 1,581,007.0 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 20,512.0 мянга төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,580,259.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 20,512.0 мянган төгрөг, нийт 1,600,147.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,590,019.4 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 10,128.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,590,019.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 1,500.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 10,600.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 928,3 мянга, нийт 13,028.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 619.0 мянга, тээвэр шатахууны зардалд 100.0 мянга, хог хаягдлын зардалд 309.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 446.1 мянга, багаж техник хэрэгслийн зардалд 5,328.9 мянга, төлбөр хураамжийн зардалд 50.0 мянга, мэдээлэл технологийн зардалд 285.0 мянга, хичээл практикийн зардалд 2,905.0 мянга, шагнал урамшууллын зардалд 2,985.0 нийт 13,028.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.



20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймаг дахь Шүүхийн тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 150 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, байршуулах хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 14-ний өдөр



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ